

**2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 10 дугаар сарын 09-ний “Даваа” гарагийн 12:00 цагаас өмнө e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
1	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 384 жилийн ойг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	НХХ
2	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/817 дугаар захирамжийн хэрэгжилт, ажлын гүйцэтгэл, үр дүн болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах.	ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд
3	Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа автозам, тохижилт, инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлийн ажлуудын гүйцэтгэлд тавих хяналтаа сайжруулж, ухсан нүх, эвдэрч гэмтсэн авто зам, явган зам талбайг нөхөн сэргээх, засварлах ажлаа чанартай гүйцэтгэж хэрэгжилтэд хяналт тавих.	ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд, Ажлын хэсэг
4	Орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд хангаж, орлогын тасалдлыг нөхөж, гүйцэтгэлийг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс, орлого бүрдүүлэгч байгууллагууд
5	Нийслэл хотын хэмжээнд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар холбогдох нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагыг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох арга хэмжээг авах.	ЗДО Б.Болормаа Цагдаагийн хэлтэс, ЗДТГ, нийт байгууллагууд
6	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхдийн тусламж, үйлчилгээ үзүүлж бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд бэлтгэл ажлаа сайтар хангах, эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлж ажиллах.	ЭМТ
7	Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын удирдлагууд өөрсдөө салбар салбарын хэмжээнд хийгдэж байгаа ажлуудынхаа гүйцэтгэл, үр дүнг, тоон мэдээлэл, судалгааг иргэд, олон нийтэд мэдээлэх.	Нийт ААНБ-ууд
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
8	Дүүргийн 2 дугаар хороонд зохион байгуулагдах “Нээлттэй хаалганы өдөр”-ийн бэлтгэл ажлыг сайтар хангаж өөрийн байгууллагын үндсэн чиглэл, онцлог болон ажлын байрны мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, үнэн бодитоор мэдээллэж ажиллах.	ЗДТГ, ТЗУХ, нийт байгууллагууд
9	СӨХ цэвэрлэгээ үйлчилгээгээ сайжруулан, иргэдэд санамж, зөвлөмж өгөх, хороодын хог хаягдлын байцаагч нар СӨХ-той ажлаа уялдуулж ажиллах.	ТХҮХ, СӨХ, Хороод
10	Засгийн газрын 2023 оны 5 ш ажиллагааны нэг болох Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд <a href="https://shilen.gov.mn/">https://shilen.gov.mn/</a> сайтын мэдээллийг шинэчлэн үнэлгээг 100 хувьд хүргэх	ТЗУХ

11	Тог тасарсан үед байгууллага, иргэдийг усаар хангах, бохирыг татан зайлуулах ажлыг шуурхай гүйцэтгэж ажиллах.	УСАТ
12	“Дулаан Багахангай” аяны хүрээнд байгууллагын дулаан алдалтыг багасгах, айл өрхүүд орон гэрээ дулаалж, нүүрс түлшээ нөөцлөх талаар зөвлөмж мэдээлэл түгээх.	ТХҮХ, нийт байгууллагууд, Хороод
13	2023 оны 11 дүгээр сарын эхээр дүүргийн 1, 2 дугаар хороонд “Мөсөн хотхон” байгуулах, үүнтэй холбогдуулан талбайн болон мөсөн байгууламжийн зураглалыг гарган 10 дугаар сарын 20-ны үед танилцуулах	Багахангай тохижилт, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР